



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар A/109

Улаанбаатар хот


### Журам батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Оюутны дуу, бүжгийн “ШУТИС-ийн Залуус” чуулгын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталж, 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Батлагдсан журмыг хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Оюутны соёл, үйлчилгээний албаны дарга (Н.Санчирбаатар), Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал), бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн захирал нар т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

	“ШУТИС-ИЙН ЗАЛУУС” ОЮУТНЫ ДУУ, БҮЖГИЙН ЧУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ MUST-SS-P01	Эхний хэвлэлт	2019.04.23
		Өөрчилсөн огноо	-
		Өөрчлөлтийн дугаар	0

ШУТИС-ийн Захирлын 2019 оны 5 дугаар сарын  
 05... өдрийн 4/09 тоот тушаалын хавсралт  
 MUST-SS-P01



# ОЮУТНЫ ДУУ, БҮЖГИЙН “ШУТИС-ИЙН ЗАЛУУС” ЧУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Боловсруулсан:

ОЮУТНЫ СОЁЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн ЗАХИРАЛ





## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Оюутны дуу бүжгийн “ШУТИС-ийн Залуус” чуулга (цаашид “Чуулга” гэх) нь оюутны санал санаачилгыг дэмжих, урлаг уран сайхнаар дамжуулан оюутныг соён гэгээрүүлэх, төлөвшүүлэх, авьяаслаг, чадварлаг хамт олон бүрэлдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.2 Чуулга нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, ШУТИС-ийн Дүрэм, Оюутны ёс зүйн дүрэм, Оюутнуудад кредитийн урамшуулал олгох журам, бусад холбогдох журмуудыг үйл ажиллагаандаа баримтална.
- 1.3 Чуулгын тогтмол үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.4 Чуулга нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, лого хэрэглэнэ.
- 1.5 Энэхүү журмыг ШУТИС-ийн нэгж, бүрэлдэхүүн сургууль, багш, оюутан, чуулгын нийт гишүүд, хамтран ажиллах байгууллагууд дагаж мөрдөнө.

## ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 Чуулгын уран бүтээлч: Шинжлэх ухаан технологийн их сургуулийн оюутан
- 2.2 Урын сан: Чуулгын уран бүтээлчдийн бүтээлийн сан хөмрөг

## ГУРАВ. ХАРИУЦЛАГА, ЭРХ ҮҮРЭГ

- 3.1 Чуулгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг ШУТИС-ийн захирлын тушаалаар батална.
- 3.2 Чуулгын зөвлөлийг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал удирдана.
  - 3.2.1 Чуулгын зөвлөлийг сард нэг удаа зарлан хуралдуулна.
- 3.3 Чуулгын зөвлөл:
  - 3.3.1 Чуулгын эрхэм зорилго, урлаг, урын сангийн бодлогыг хэрэгжүүлнэ.
  - 3.3.2 Чуулгын үйл ажиллагаа, уран бүтээлийн жилийн төлөвлөгөөг хэлэлцэн батална.
  - 3.3.3 Чуулгын уран бүтээлчдийн тоглолтын үнэ ханш, ажлын хөлсийг тогтооно.
  - 3.3.4 Чуулгын авьяас чадвартай уран бүтээлч оюутнаас тодорхой шалгуураар үйл ажиллагааг нь дүгнэн, ШУТИС-ийн оюутнуудад кредитийн урамшуулал олгох журмын 2.3-р заалтын дагуу урамшуулал олгох саналыг гаргана.
  - 3.3.5 Чуулгын үйл ажиллагааны явцын зураглал, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай маягтуудыг хэлэлцэж батална.
- 3.4 Оюутны соёл, үйлчилгээний алба:
  - 3.4.1 Чуулгын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
  - 3.4.2 Чуулгын үйл ажиллагааны талаар мэдээлнэ.
  - 3.4.3 Чуулгын үйл ажиллагаа, уран бүтээлийн жилийн төлөвлөгөөг боловсруулна.
  - 3.4.4 Гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, иргэдтэй хуулийн хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.
  - 3.4.5 Бүрэлдэхүүн сургуулиуд, газар, албадуудаас санал авч чуулгын зөвлөлийг сонгоно.
  - 3.4.6 Чуулгад чадварлаг, авьяастай оюутан залуусыг шалгаруулан сонгож авна.





- 3.4.7 Чуулгын уран сайхны удирдагч нь Оюутны соёл, үйлчилгээний албаны урлаг, соёл хариуцсан мэргэжилтэн байна.
- 3.4.8 Чуулгын уран бүтээлчдийн бүтээх, туурвих нөхцөл бололцоог хангах тал дээр анхаарч, ур чадварыг дээшлүүлэхэд нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- 3.4.9 Сахилга дэг журам, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулах, цаг ашиглалт болон өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавин ажиллана.
- 3.4.10 Уран бүтээл туурвих, нөхцөл боломж, стандартад нийцсэн өрөө байр, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг, хувцас, хэрэглэлээр хангуулж ажиллана.
- 3.5 Чуулгын уран бүтээлчид:
- 3.5.1 Их, дээд сургууль, дотоод гадаадын олон улсын байгууллагатай уран бүтээлийн чиглэлээр хамтран ажиллана.
- 3.5.2 ШУТИС-ийн хэмжээнд болон бүрэлдэхүүн сургуулиудын нэгдсэн арга хэмжээнд идэвхтэй, санаачлагатай нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцоно.
- 3.5.3 Чуулга нь жил бүр чуулгын нэгдсэн тайлан тоглолт хийнэ.

### **ДӨРӨВ. ЧУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 4.1 Чуулгад оюутан элсүүлэх:
- 4.1.1 ШУТИС-д үйл ажиллагаа явуулж буй оюутны клубүүдээс авьяас чадвартай оюутныг элсүүлнэ.
- 4.1.2 ШУТИС-ийн оюутны урлагийн наадмаас жил бүр авьяаслаг оюутныг сонгон шалгаруулж авна.
- 4.1.3 Чуулгын нийт бүрэлдэхүүн 100-аас хэтрэхгүй уран бүтээлчтэй байна.
- 4.2 Санхүүжилт:
- 4.2.1 Чуулга нь явуулсан ажил үйлчилгээний төлбөр, төсөл, өөрийн үйл ажиллагааны бусад орлого, эх үүсвэрээр санхүүжиж ажиллана.
- 4.2.2 Чуулгын санхүүгийн үйл ажиллагааг ШУТИС-ийн захиргааны дансыг ашиглан явуулна.
- 4.3 Чуулгын уран бүтээлийн төрөл:
- Хамтлаг**
- Амьд хөгжим (гоцлол гитар, аргил гитар, ритм гитар, бөмбөр)
  - Ардын хөгжим (морин хуур, ятга, лимбэ, ёочин)
  - Дуу (нийтийн, орчин үеийн, сонгодог, найрал)
  - Цэнгээнт бүжиг
  - Чөлөөт бүжиг
  - Ардын бүжиг
- Гоцлол**
- Дуу ( ардын болон орчин үеийн, сонгодог )
  - Бүжиг (үндэсний болон орчин үеийн, сонгодог )
  - Хөгжим (үндэсний болон орчин үеийн, сонгодог )
- Хөтлөгч**
- Концертын
  - Хурлын
  - Олон нийтийн үйл ажиллагааны